



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 1100

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгч сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 25 дугаар дүгнэлтийн дагуу Өвөрхангай аймгийн Хархорин суманд шинээр хийх авто замын гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг 9.500.000 (есөн сая таван зуун мянга) төгрөгөөр Оргилт-од ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан зураг төсөв боловсруулах явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100237

D: My Doc. Tushaal. ZDTG